

ДОРНОД АЙМАГТ “НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ДОЛОО ХОНОГ” АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2025.06.23

Чойбалсан хот

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга бөгөөд Нээлттэй засгийн түншлэлийн үндэсний даргаас аймгийн Засаг даргад хандан ирүүлсэн 2025 оны хэг/1122 дугаар албан бичигтэй танилцаж, “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног” арга хэмжээг зохион байгуулан ажиллаа.

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар нь “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног” арга хэмжээний хүрээнд нээлттэй засгийн тэргүүлэх чиглэлүүдийн нэг болох “Цахим засаглал” болон “Авлига” сэдвийн хүрээнд үйл ажиллагаа хэрэгжүүллээ.

Энэхүү ажлын хүрээнд орон нутгийн иргэдийн цахим хэрэглээ, E-Mongolia системийн ашиглалтын байдлыг судалж, цахим үйлчилгээний хүртээмж, хэрэглээтэй холбоотой тулгамдаж буй асуудлуудыг газар дээр нь шийдвэрлэх зорилго бүхий рийл (reel) бичлэг бэлтгэн, “Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар” цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэлээ.

2025 онд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр khutulbur.iaac.mn цахим сайтад хэрэгжилтийн явцыг байршуулсан. Дорнод аймгийн Засаг даргын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан тус төлөвлөгөөний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2025 оны "аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох тухай" 37 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 26 агентлаг, 14 сумын Засаг дарга, 4 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мөн 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр дээрх байгууллагуудын удирдлага, албан хаагч нарт Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг танилцуулж, холбогдох зөвлөмжийг цахим болон танхим хосолсон байдлаар өгсөн. Авлигатай тэмцэх газартай хамтран 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Авлигын эсрэг гэмт хэрэг сэдвээр аймгийн 26 агентлаг, 14 сумын Засаг даргын Тамгын газрын 200 гаруй албан хаагчдад цахим сургалтыг зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулан, сумын Засаг дарга болон Агентлагийн дарга нарт хүргүүлсэн. Аймгийн 14 сумдын төрийн албан хаагчдад Авлигаас урьдчилан сэргийлэх болон нийтийн албанд хувийн, нийтийн ашиг сонирхлыг зохицуулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх зүйн сургалтыг зохион байгуулсан. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн 454 ширхэг ном, гарын авлага, 5 төрлийн 215 ширхэг зурагт хуудас, авлигыг мэдээлэх 110 дугаарын 2 төрлийн 100 ширхэг наалтыг мөн 24 агентлаг, 14 сумдад хүргэж ажилласан. “Шударга ёс хөгжил дэвшилд” авлигын эсрэг самбарыг аймгийн Засаг даргын тамгын газарт байршуулж авлигын эсрэг үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас зохион байгуулж буй “Нээлттэй засгийн түншлэлийн долоо хоног - 2025” арга хэмжээний хэсэг болох **хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх** зорилгын хүрээнд Европын Холбооны санхүүжилттэй НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй

“Өөрчлөлтийн элч төлөөлөгчид: Хариуцлагатай бизнесийн төлөөх залуус ба хэвлэл мэдээлэл” цахим сургалтад аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн агентлаг хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Цогтбаатар нар хамрагдсан. Тус сургалтаар НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс 2011 онд баталсан “Бизнес ба хүний эрхийн Удирдах Зарчмууд”, Монгол Улсын Засгийн газраас 2023 онд 231 тоот тогтоолоор баталсан “Бизнес ба хүний эрх” Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөний агуулга, НҮБ Бизнес ба Хүний эрхийн Удирдах зарчмуудын 1-р тулгуур багана болох Хүний эрхийг хамгаалах Төрийн үүрэг агуулгын хүрээнд зохион байгуулагдсан. Үүний хүрээнд “Орон нутаг дахь хүний эрхийг хангах арга хэмжээ”-г зохион байгуулах ажлын удирдамжийг аймгийн Засаг даргын орлогчоор батлуулан, тус ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан бөгөөд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд төлөвлөгөө, тайланг боловсруулахаар бэлтгэл ажлын ханган ажиллаж байна.

Мөн Аймгийн Засаг даргын тамгын даргын 2025 оны сумдад зөвлөн туслах ажлын удирдамжийн дагуу аймгийн 13 сумдад ажиллаж иргэд, төрийн албан хаагчдад Нээлттэй засгийн түншлэлийн 10 үнэт зүйлийн болон төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай, Авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээллүүдийг хүргэсэн.

-ооОоо-